

Ерөнхийлөгч Хэнри Б.Айринг

Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх



Зөв шударга байдалаар ЗЭВСЭГЛЭХ НЬ

Дэлхий дээрх Бурханы бошиглогч, ерөнхийлөгч Томас С.Монсон “Өнөөдөр бид урьд хожид байгаагүй ихээр газар аван тэлсэн нүгэл, худал хуурмаг, хилэнцтэй тэмцэхээр зогсож байна”¹ хэмээн тунхагласан билээ.

Ерөнхийлөгч Монсон энэ үгээ 50 жилийн өмнө хэлж байсан гэдгийг мэдвэл та нар гайхах уу? Хэрэв бид тухайн үед урьд хожид байгаагүй их нүгэл хилэнцтэй тэмцэлдэж байсан юм бол одоо биднийг үүнээс хэр их нүгэл хилэнц заналхийлж байгаа бол? Их Эзэн манай эрин үеийн талаар “дайсан нэгдээд байна” (С ба Г 38:12) хэмээн тунхагласан нь яахын аргагүй үнэн билээ.

“Бидний тулалдахаар дуудагдсан”² дайн биднийг энэ дэлхийд мэндлэхээс өмнө эхэлсэн. Энэ нь бүр дэлхий бүтээгдэхээс ч өмнө эхэлсэн. Тухайлбал Сатан бослого гаргаж, “хүмүүний сонгох эрхийг эрэлхийлсэн” (Мосе 4:3) тэр үед буюу мөнх бус байдлын өмнөх оршихуйд хэдэн мянган жилийн өмнө эхэлсэн.

Сатан тэрхүү тулаанд ялагдаж, “дэлхий уруу хаягд[сан]” (Илчлэлт 12:9) бөгөөд энд өнөөдөр ч дайнаа үргэлжлүүлсээр байгаа билээ. Энэ дэлхийд “тэрээр Бурханы гэгээнтнүүдтэй дайтдаг, мөн тэднийг [худал хуурмаг, хууран мэхлэлт, уруу таталтуудаар] тойрон бүсэлдэг ажгуу” (С ба Г 76:29).

Сатан бошиглогч, төлөөлөгчдийн эсрэг болон ариун явдлын хууль, гэрлэлтийн ариун нандин байдлын эсрэг дайтдаг. Тэр гэр бүл, ариун сүм ба сайн сайхан, ариун нандин зүйлсийн эсрэг дайтдаг.

Бид ийм дайсантай хэрхэн дайтах вэ? Бид дэлхийг

нөмөрч буй хилэнцийн эсрэг хэрхэн дайтах вэ? Бидний хуяг дуулга юу байх вэ? Бидний талд хэн зогсох вэ?

Хурганы хүч

Бошиглогч Иосеф Смит Сатан биднийг зөвшөөрсөн тохиолдолд л биднийг эзэмдэх хүчтэй байдаг хэмээн заажээ.³

Бидний өдрүүдийн талаар Нифай “Хурганы сүмийн гэгээнтнүүдийн дээр, мөн газрын гадаргуугаар нэг тархсан Их Эзэний гэрээ байгуулсан хүмүүс дээр буух Бурханы Хурганы хүчийг болгоов; мөн *тэд ялгуусан алдар суунд зөв шударга байдал хийгээд Бурханы хүчээр зэвсэглэсэн бай[хыг]*” харсан (1 Нифай 14:14; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн).

Бид өөрсдийгөө зөв шударга байдал хийгээд хүчээр хэрхэн зэвсэглэх вэ? Бид Хүндэтгэлийн өдрийг сахиж, санваарыг хүндэтгэн дээдэлдэг. Бид ариун нандин гэрээнүүдийг хийн, сахиж, гэр бүлийн түүх дээрээ ажилааж, ариун сүмд ордог. Бид зогсолтгүй наманчилж, Их Эзэнээс “нүглүүддээ өршөөлийг хүлээж авч болохын тулд Христийн цагаатгагч цусыг нөлөөлүүлээч” (Мозая 4:2) хэмээн гуйдаг. Бид залбирч, үйлчлэн, гэрчилж, Есүс Христэд итгэх итгэлээр үйлддэг.

Бид мөн өөрсдийгөө “амьдралын үгсийг оюундаа ямагт нөөцлөхийн” хэрээр зөв шударга байдал хийгээд хүчээр зэвсэглэдэг (С ба Г 84:85). Бид ариун судруудыг болон ирэх ерөнхий чуулгануудаар Их Эзэний хүсэл, оюун санаа, дуу хоолойг илчлэх Их Эзэний сонгосон үйлчлэгчдийн үгсийг судалснаар тэр үгсийг оюундаа

нөөцөлнө (С ба Г 68:4).

Бид хилэнцийн эсрэг тэмцэхдээ хөшигний аль ч талаас тусламж авах эрхтэй гэдгээ үргэлж санах ёстой. Бидний талд Бурхан Мөнхийн Эцэг, Их Эзэн Есүс Христ, Ариун Сүнс гурав байдаг.

Мөн харж байгаагүй тэнгэрийн дайчид бас байгаа. Елиша хилэнцэт их цэргийн эсрэг зогсохдоо айж тэвдсэн нэгэн залуу “Бүү айгтун.” “Учир нь бидэнтэй хамт байгчид нь тэдэнтэй хамт байгчдаас илүү олон юм” хэмээн хэлсэн (Хаадын дэд 6:15–16-г үзнэ үү).

Бид айх хэрэггүй. Бурхан гэгээнтнүүддээ хайртай. Тэр хэзээ ч биднийг орхихгүй.

Бурхан бидний залбиралд хариулан хилэнцээс чөлөөлөх гуйлтуудыг маань биелүүлсэн гэдгийг би мэднэ. Бид Бурхан Эцэг, дэлхийн Аврагч, Ариун Сүнсний тусламжтайгаар бидэнтэй тулгарах ямар ч хилэнцийг тэвчиж ялж гарах хангалттай их хүчийг хүлээн авах болно гэдэгт итгэлтэй байж болно гэдгийг би гэрчилж байна.

Эцэст нь бид ялагч болох болно гэдэгтээ итгэлтэй байж болохын тулд зөв шударга байдлаар зэвсэглэх болтугай.

ЭШЛЭЛҮҮД

1. Томас С.Монсон, “Correlation Brings Blessings,” *Relief Society Magazine*, 1967 оны 4-р сар, 247.
2. “We Are All Enlisted,” *Hymns*, 250-р дуулал.
3. *Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит* (2007), 214-ийг үзнэ үү.

ЭНЭХҮҮ ЗАХИАСААС ЗААХ НЬ

Биднийг хилэнцийн эсрэг дайнд тулалдаж байгааг ерөнхийлөгч Айринг сануулав. Та нар зааж буй хүмүүстэйгээ хамт “Бид тулалдахаар дуудагдсан” (*Hymns*, 250) дууллыг дуулж болно. Тэгээд та тэднийг хэрхэн зөв шударга байдлаар дамжуулан хамгаалуулж байснаа хуваалцахыг хүсээд, зөв зохистой мэдээллийн хэрэгсэл сонгох, гэр бүлийн зөвлөгөөн хийх, долоо хоног бүр гэр бүлийн үдшээ хийх гэх мэтчилэн гэр бүлээ Сатаны эсрэг хамгаалах олон арга замыг бодож олоход урьж болно. Та гэр бүлийнхээ хамгаалалтын хэрмийг хэрхэн барих талаар залбирч, тунгаан бодоход тэднийг уриалж, санаануудаа хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргахад урамшуулан дэмжиж болно.

ӨСВӨР ҮЕИЙНХЭН

Би шийдвэрээ гаргасан

Мэдисон Томпсон

Б и нэгэн удаа залуу эмэгтэйчүүдийн ангидаа бэлгийн харьцааны цэвэр ариун байдлын тухай чухал

хичээлд суусан бөгөөд хичээлийн сэдэв өсвөр үеийнхний олонхыг нь тавгүйтүүлж билээ. Би тэр өдөр сурсан зүйлээ бүгдийг нь санахгүй байгаа ч удирдагч маань бэлгийн харьцааны хувьд цэвэр ариун байх хувийнхаа жишгээс хуваалцсаныг үргэлж санадаг. Түүний үгс зүрх сэтгэлд минь үлдэж, би үүнийг өөрийнхөө хувийн баримтлах эрхэмлэх чанар болгохоор анхааралтай бодож шийдсэн юм.

Нэг удаа намайг спортын үйл ажиллагааны дараа гэр рүүгээ автобусаар явж байх үед автобусанд байсан хэн нэгэн үнэнээ хэлэх эсвэл шийтгэл хүлээх гэдэг тоглоомыг эхлүүлсэн юм. Бид уйдаж байсан учраас би хэсэг хүүхдийн хамт тоглохоор болов. Миний ээлж ирэхэд би зөв биш гэдгийг нь мэдэж байсан нэгэн зүйлийг хийх шийтгэл авлаа. Үнэхээр хүндхэн шийдвэр байж болох байсан ч Залуу эмэгтэйчүүдийн удирдагчийн маань хэлсэн үг санаанд минь зурсхийн орж ирж, сонголт хийхэд хялбар болсон юм. Би тэр даруй тоглоомд оролцохгүй байхаар шийдэв. Би тухайн нөхцөл байдалд юу хийхээ аль хэдийн шийдчихсэн байсан юм.

Бид сүм рүү явж, тэнд заалгасан зүйлээ суралцах гэж хичээхдээ илүү агуу сүнслэг хүч чадлаар болон дэлхийн уруу таталтуудаас хамгаалах хамгаалалтаар адислагдах болно гэдгийг би мэднэ. *Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.*

ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛАВ

Хуяг дуулгаа өмс

Ө нөөдөр дэлхий дээр маш олон муу зүйл байна. Сайн мэдээ бол биднийг хамгаалдаг бамбай юм. Ерөнхийлөгч Айрингийн хэлсэн өөрсдийгөө хамгаалахын тулд хийх 10 зүйлийг уншаарай. Дараа нь өөрийнхөө бамбайг зураад, буд.

1. Хүндэтгэлийн өдрийг ариунаар сахь.
2. Санваарыг хүндэтгэн дээдэл.
3. Гэрээ хийж, тэдгээрийг сахь.
4. Гэр бүлийн түүх дээрээ ажилла.
5. Ариун сүмд оч.
6. Наманчил.
7. Залбир.
8. Бусдад үйлчил.
9. Гэрчлэлээ хуваалц.
10. Судруудыг унш.

© 2017 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан. АНУ-д хэвлэв. Англи эхийн зөвшөөрөл: 6/16. Орчуулгын зөвшөөрөл: 6/16. *First Presidency Message, March 2017*-ийн орчуулга. Mongolian. 97923 363



Есүс Христийн болон Түүний Цагаатгалын боломж олгогч хүч

Энэ материалыг залбирч судлан, хуваалцах зүйлээ мэдэхийн тулд сүнслэг өдөөлт эрэлхийл. Халамжийн нийгэмлэгийн зорилгыг ойлгох нь мөнх амьдралын адислалыг хүртэхэд Бурханы охидыг хэрхэн бэлтгэх вэ?

Итгэл, гэр бүл, халамж

“Надад хүч өгөгч Түүгээр би бүгдийг хийж чадна” (Филиппой 4:13). “Хэдийгээр бидэнд сул талууд байдаг ч бид тэдгээрийг даван туулж чадна.” “Хэрэв бид өөрсдийгөө даруусган, итгэлтэй байж чадвал Бурханы ач ивээлээр сул дорой талууд маань үнэхээр хүчирхэгжих юм”¹ хэмээн Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф хэлжээ.

Аврагч маань Сургаал ба Гэрээнд “Би та нарын нүүрний өмнө явах болно. Би та нарын баруун гар талд мөн та нарын зүүнтээ байх болно, мөн миний Сүнс та нарын зүрх сэтгэлд, мөн миний тэнгэр элчүүд та нарыг дэмжихийн тулд та нарын эргэн тойронд байх болно” (С ба Г 84:88) хэмээн хэлсэн билээ.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Дэвид А.Бэднар “Нифай бол Аврагчийн боломж

олгогч хүчийг мэдэж, ойлгож, найдсан хүний жишээ юм. Нифайн ах нар түүнийг бөх олсоор хүлж, алахаар төлөвлөсөн. Нифай ‘Ай Их Эзэн танд итгэх миний итгэлийн улмаас та намайг ах нарын минь гараас зайлуулаач, тийм ээ, намайг хүлсэн энэ хүлээсийг тасар татах хүчийг өгөөч надад’ (1 Нифай 7:17; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн) хэмээн залбирсныг санагтун.

. . . Нифай нөхцөл байдлаа өөрчилж өгөөч гэж залбираагүй. Тэр үүний оронд нөхцөл байдлаа өөрчлөх хүч чадлыг өгөөч гэж залбирчээ. Тэрээр Цагаатгалын боломж олгогч хүчийг тодорхой мэддэг, ойлгодог мөн үүнийг биеэрээ үзсэн байсан тул энэ маягаар залбирсан гэдэгт би итгэдэг.

Нифайн хүлээс ид шидийн мэт бутуйнаас нь сулран тасарсан гэж би боддоггүй. Харин тэр эхлээд

төрөлх чадвараасаа илүү их хүч чадал, уйгагүй оролдлогоор адислагдаж, дараа нь ‘Их Эзэний хүчээр’ (Мозая 9:17) хүлээсийг мушгин угзрахад олс тасарч суларсан гэж би боддог.”²

Нэмэлт судар, мэдээлэл

Исаиа 41:10; Ифер 12:27;
reliefsociety.lds.org

Эшлэлүүд

1. Дийтр Ф.Угдорф, “Ач ивээлийн бэлэг,” 2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 99.
2. Дэвид А.Бэднар, “Strength beyond Our Own,” *New Era*, 2015 оны 3-р сар, 4.

Үүнийг эргэцүүлэн бод

Есүс Христийн болон Түүний цагаатгагч золиослолын боломж олгогч хүч сул дорой талуудаа хүчирхэг болгоход бидэнд хэрхэн тусалдаг вэ?